

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЫН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

1999 оны ¹¹ дүгээр сарын ⁶ ны өдөр

Дугаар ^{A/1289/233} Улаанбаатар хот

Нийслэлийн гуравдугаар амаржих газар байгуулах тухай

Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Батлан хамгаалахын сайд, Төрийн өмчийн Хорооны дарга, нийслэлийн Засаг даргын 1999 оны А/193/149/265/289 тоот тушаал, захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1.Нийслэлийн гуравдугаар амаржих газрыг 60 ортойгоор байгуулж, захирлаар нь Төмөрдэй овогтой Доржпүрэвийг 1999 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн томилж, албан тушаалын цалинг ТҮ - 10 зэрэглэлээр тогтоосугай.

2.Нийслэлийн гуравдугаар амаржих газрын дүрмийг нэгдүгээр, ажиллах албан тушаалтны жагсаалтыг хоёрдугаар, амаржих газрын үйл ажиллагааг эхлүүлж, захирлын ажлыг хүлээлгэн өгөх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Нийслэлийн гуравдугаар амаржих газрын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах төсөв, засвар, зөөлөн эдлэл авах зардлыг санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/-т үүрэг болгосугай.

4.Барилгыг хүлээн авч, засварлахтай холбогдох зардалд хяналт тавих, тус амаржих газарт шаардагдах үндсэн хөрөнгийг бүрдүүлж хангах ажлыг зохион байгуулах, амаржих газрын захиралтай "Өмч эзэмшлийн гэрээ"-г зохих журмын дагуу байгуулж ажиллахыг Нийслэлийн өмчийн газар /Буяншөнх/-д үүрэг болгосугай.

5.Зэвсэгт хүчний клиникийн төв эмнэлгээс поликлиникийн байрыг түүний ашиглалтын зардлын хамтаар шилжүүлэн авч уг байранд хийх засвар үйлчилгээг 1999 оны 12 сарын 30-ний дотор хийж дуусгахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Е.Тэрбиш/, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/ нарт үүрэг болгосугай.

6.Нийслэлийн гуравдугаар амаржих газарт шаардагдах багаж, аппарат, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл авах, их засвар хийх хөрөнгийг Нийслэлийн 2000 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Ч.Бат/-т даалгасугай.

7. Нийслэлийн гуравдугаар асаржих газрын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Салбарын бодлого зохицуулалтын газар Ш.Энхбат/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Е.Тэрбиш/ нэрт тус тус даалгасугай.

8. Энэхүү хамтарсан тушаал захиралж гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/215 /Ураг, нярайн эрүүл мэндийн тусламжийн төвийн талаар авах зарим өргө хэмжээний тухай/ тоот тушаалыг хүчингүй болсонд тооцугай.

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД


С.СОНИН



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



НИЙСЛЭЛИЙН ГУРАВДУГААР АМАРЖИХ ГАЗРЫН ДҮРЭМ.

Байгууллагын нэр: Нийслэлийн гуравдугаар амаржих газар.

Оршин буй газар: Баянзүрх дүүрэг.

НЭГ: Байгууллагын зорилго чиг үүрэг:

1. Нийслэлийн гуравдугаар амаржих газар нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн нийслэлийн захиргааны байгууллагын шууд харъяа, бие даасан төсөв санхүүгийн үйл ажиллагаатай, анагаах ухааны нарийн мэргэжлийн оношлогоо, эмчилгээний чиглэлээр хотын хүрээнд үйлчилгээ явуулдаг, НҮЭМ болон нярайн багц тусламж үзүүлэх мэргэшсэн клиник, тасаг, лаборатори бүхий оношлогоо, эмчилгээ, сургалтын үйл ажиллагаатай эрүүл мэндийн байгууллага, төрийн үйлчилгээний эмнэлэг мөн.
2. Нийслэлийн гуравдугаар амаржих газар нь нярай хүүхэд болон эх, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх талаар гарсан Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн төр захиргааны байгууллагын шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллана.
3. Нийслэлийн гуравдугаар амаржих газар нь оношлогоо, эмчилгээ, сургалтын үйл ажиллагаа явуулах клиник, тасаг, салбар нэгжтэй байна.
4. Нийслэлийн гуравдугаар амаржих газар нь байгууллагын тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай, бие даасан харилцах данстай хуулийн этгээд бөгөөд байгууллагын эрх, үүрэг нь Монгол улсын төрийн ба орон нутгийн өмчийн тухай, "эрүүл мэндийн" хууль бусад хуулинд нийцүүлэн боловсруулсан эрхийн актууд болон энэхүү дүрмээр баталгаажигдана.

Хоёр: Удирдах бүрэлдэхүүн, түүний эрх хэмжээ:

1. Нийслэлийн гуравдугаар амаржих газрын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар тогтоогдож тус амаржих газрын оношлогоо-эмчилгээний ажлууд түүний мэргэжлийн удирдлагын хяналтад явагдана.
2. Нийслэлийн гуравдугаар амаржих газрын захирлыг ЭМНХЯ-ны сайд, Нийслэлийн засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар томилж, чөлөөлнө.
3. Амаржих газрын захирал нь үйл ажиллагааг удирдах, зохицуулах, хянах үүрэг бүхий захиргааны зөвлөлийг байгуулж ажиллана.
4. Амаржих газрын зорилгыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг стратегийн удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус

- итгэмжлэгдсэн удирдах зөвлөлийг Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаалыг үндэслэн байгуулж ажиллуулна.
5. Амаржих газрын захирал нь мэргэжлийн клиник, эдийн засаг санхүү эрхэлсэн дэд захиралтай байж болно. Дэд захирлыг амаржих газрын захирлын тушаалаар томилно.
 6. Эмчилгээ, үйлчилгээний ажлыг эрхлэх үүрэг бүхий нэгж, тасаг, салбарыг амаржих газрын захирлын тушаалаар томилогдсон дарга эрхлэгч нар удирдах бөгөөд эмч ажилчдыг ажилд авах, чөлөөлөх, халах, томилох, ажил үйлчилгээний онцлог болон хэрэгцээ шаардлагаас шалтгаалан нэгжийг салгах, нийлүүлэх, татан буулгах асуудлыг захиргааны зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, захирлын тушаалаар хэрэгжүүлнэ.
 7. Амаржих газрын захирал нь клиник, тасаг нэгжүүдийн дарга, эрхлэгч нарыг өдөр тутмын удирдлагаар ханган клиник, тасаг хоорондын үйл ажиллагааг зохицуулна.
 8. Мэргэжлийн клиник, тасаг нэгжийг нарийн мэргэжил эзэмшсэн, эмчийн зэрэгтэй эмч, мэргэжилтэн нар удирдах бөгөөд тухайлсан нарийн мэргэжлийн зөвлөхүүдтэй байж болно. Зөвлөх эмч нарыг тухайн тасгийн эрхлэгч нартай зөвшилцсөний үндсэн дээр захирлын тушаалаар томилно.
 9. Амаржих газрын захирал нь дэд захирал, санхүүгийн аппаратын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан амаржих газрын ажлын дэглэмийг бусад эмнэлгийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулж, эмнэлэг үйлчилгээний хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэн гүйцэтгэлийн хяналт тавих ажлыг хариуцна.
 10. Дэд захирал, тасгийн эрхлэгч, зөвлөхүүд нь оношлогоо-эмчилгээ, үйлчилгээний чанарыг захиргааны өмнө хариуцна.
 11. Амаржих газрын мэргэжлийн боловсон хүчнийг тухайн клиникийн тасгийн эрхлэгч нартай зөвшилцсөний үндсэн дээр АУИС /анагаах ухааны бакалаврын боловсролыг эзэмшсэн/-ийг тухайн нарийн мэргэжил эзэмшин, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан туршлага дадлагатай эмч нарыг уралдаант шалгаруулалтаар сонгон авна.
 12. Клиник, тасгийн эрхлэгч, зөвлөхүүд нь харьяа клиник, тасаг нэгжүүдийн эмчилгээ, үйлчилгээний ажлын чанарыг хариуцан зохицуулах үүрэг хариуцлага хүлээх ба тус тусын ажил үүргийн хуваарьтай байна.
 13. Амаржих газар нь өөрийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан бусад эмнэлэг, төвөөс ялгаатай эмнэлэг үйлчилгээний ачааллын норм, норматив, стандарт үнэлгээтэй байж болно.
 14. Амаржих газар нь өөрийн дэргэд нээлттэй үйлчилгээтэй эмийн санг ажиллуулна. Эмийн сан нь төвийн хэрэгцээг чанарын баталгаа хангасан эм тариа, багаж хэрэгсэл, бараа материалаар дотоод, гадаадын зах зээлээс мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн ашигтай нөхцөл, хөнгөлөлттэй үнээр олж нийлүүлж болно.
 15. Эмчилгээ, үйлчилгээ, оношлогоонд шаардагдах төсөв хөрөнгийг төсөвлөж төрийн захиргааны болон санхүүгийн дээд байгууллагын

өмнө хамгаалан баталгаажуулах, гүйцэтгэлд хяналт тавих зарчмыг баримтлан ажиллана.

Гурав: Нийслэлийн гуравдугаар амаржих газрын үндсэн үүрэг:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт, эхчүүд эмэгтэйчүүд, нярай хүүхдэд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг мэргэжлийн чанарын өндөр түвшинд хариуцан гүйцэтгэнэ.
2. Үйлчлүүлж буй эх, эмэгтэйчүүд, нярайн эрүүл мэнд өвчлөлд дүн шинжилгээ, судалгаа хийж эрүүл мэндийг сайжруулах, өвчлөл нас баралтыг бууруулах талаар ЭМНХЯ, ЭМГ болон бусад байгууллагатай хамтран ажиллана.
3. Эмч, ажилтан, ажилчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлэх замаар мэргэжлийн эрхээ хамгаалах бэлтгэлийг ханган, сургалтын мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.
4. Анагаах ухааны ололт, оношлох, эмчлэх дэвшилттэй арга, технологийг нэвтрүүлэн үр дүнг тооцон ажиллана.
5. Хэвтэн эмчлүүлэгсэд болон поликлиникээр үйлчлүүлэгчдэд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих сурталчилгаа зохион байгуулна.

Дөрөв: Нийслэлийн гуравдугаар амаржих газрын эрх:

1. Амаржих газар нь өөрийн үйл ажиллагааг дэмжих хандив, тусламж үзүүлэх гадаадын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах зарчмыг мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх.
2. Амаржих газар нь эмчилгээ, үйлчилгээ, сургалт судалгааны ажлын ололт, дутагдлын талаар санал зөвлөмж боловсруулж дээд шатны байгууллагад уламжлах.
3. Тэргүүний ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах.
4. Эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал, шийдвэр гарган мөрдүүлэх, хөдөлмөрийн сахилга, ажлын хариуцлага алдсан хүмүүст арга хэмжээ авах.
5. Тус амаржих газар нь бусад байгууллагатай эрх тэгш харилцах, гэрээ хэлцэл хийх, харилцан хариуцлага хүлээх.
6. Төр засаг болон ЭМНХЯ-наас тогтоосноос бусад ажил үйлчилгээний үнэ тарифийг тогтоож мөрдөх.
7. Хуулиар хориглоогүй ажил үйлчилгээ явуулсны үр дүнд олсон орлогыг амаржих газрын захиргаа өөрөө захиран зарцуулах.
8. Төрийн өмч эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хувьчлах эд хөрөнгийг хадгалах хамгаалах ажлыг төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн зохих заалтын дагуу явуулах.
9. Амаржих газрын хэмжээнд мөрдөгдөх заавар дүрэм, журам, аргачлалыг боловсруулж батлан мөрдүүлэх.
10. Өөрийн байгууллагын ажиллагсдын цалингийн жишиг, мэргэжлийн цол зэрэг, ур чадвар, урамшууллын нэмэгдэл хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд тогтоох, олгох.
11. Боловсон хүчин, санхүү-эдийн засгийн үйл ажиллагаа, гадаад харилцааны асуудлыг бие даан шийдвэрлэх.

12. Энэхүү дүрмийг ЭМНХ-ын Сайд, Нийслэлийн засаг даргаар батлуулан мөрдөх.

Тав: Санхүүжилтийн эх үүсвэр:

1. Нийслэлийн гуравдугаар амаржих газрын санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, төлбөрт үйлчилгээ, өөрийн аж ахуйн үйл ажиллагааны орлого, хандив, зээл тусламж, түрээсийн орлого зэрэг эх үүсвэрээс бүрдэнэ.

Зургаа: Хөрөнгө зарцуулах зориулалт:

1. Төсвийн хуулийн дагуу зардлын төрөл бүрээр зориулалтын дагуу хөрөнгө зарцуулна.
2. Батлагдсан төсвийг хэмнэлттэй зарцуулна.

Долоо: Өөрчлөн байгуулах, татан буулгах:

1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэлийн хотын захиргаатай тохиролцсоны үндсэн дээр Нийслэлийн гуравдугаар амаржих газрын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгосон тохиолдолд татан буугдсанд тооцогдоно.
2. Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох үндэслэл нь мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, санхүү аж ахуйн хувьд үйл ажиллагаа цаашид хэвийн явуулах боломжгүй болсон зэрэг болно.

ЭМНХ-ын сайд, Нийслэлийн засаг даргын
 хамтарсан 1999 оны 10 дугаар тушаал,
 захирамжийн хоёрдугаар хавсралт.

**НИЙСПЭЛИЙН ГУРАВДУГААР АМАРЖИХ ГАЗАРТ АЖИЛЛАХ АЛБАН
 ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ.**

| № | Албан тушаал | Сарын дундаж цалин | Жилийн дүн |
|----|------------------------------------|--------------------|------------|
| 1 | Захирал | | |
| 2 | Ерөнхий ня-бо | | |
| 3 | Эмчилгээ эрхэлсэн орлогч | | |
| 4 | Аж ахуй эрхэлсэн орлогч | | |
| 5 | Боловсон хүчин | | |
| 6 | Эмчилгээ, чанарын хяналтын менежер | | |
| 1 | Нярайн их эмч | | |
| 2 | Нярайн их эмч | | |
| 3 | Нярайн их эмч | | |
| 4 | Нярайн их эмч | | |
| 1 | Сэхээн, мэдээ алдуулгын их эмч | | |
| 2 | Сэхээн, мэдээ алдуулгын их эмч | | |
| 3 | Сэхээн, мэдээ алдуулгын их эмч | | |
| 1 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 2 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 3 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 4 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 5 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 6 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 7 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 8 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 9 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 10 | Эх барих, эмэгтэйчүүдийн их эмч | | |
| 1 | Эх баригч | | |
| 2 | Эх баригч | | |
| 3 | Эх баригч | | |
| 4 | Эх баригч | | |
| 5 | Эх баригч | | |
| 6 | Эх баригч | | |
| 7 | Эх баригч | | |
| 8 | Эх баригч | | |
| 9 | Эх баригч | | |
| 10 | Эх баригч | | |
| 1 | Лаборант | | |
| 1 | Сувилагч | | |
| 2 | Сувилагч | | |
| 3 | Сувилагч | | |
| 4 | Сувилагч | | |
| 5 | Сувилагч | | |
| 6 | Сувилагч | | |
| 7 | Сувилагч | | |
| 8 | Сувилагч | | |
| 9 | Сувилагч | | |
| 10 | Сувилагч | | |
| 11 | Сувилагч | | |

| | | | |
|-----|-------------------------|--|--|
| 12 | Сувилагч | | |
| 13 | Сувилагч | | |
| 14 | Сувилагч | | |
| 15 | Сувилагч | | |
| 16 | Сувилагч | | |
| 17 | Сувилагч | | |
| 18 | Сувилагч | | |
| 19 | Сувилагч | | |
| 20 | Сувилагч | | |
| 21 | Сувилагч | | |
| 1. | Асрагч | | |
| 2. | Асрагч | | |
| 3. | Асрагч | | |
| 4. | Асрагч | | |
| 5. | Асрагч | | |
| 6. | Асрагч | | |
| 7. | Асрагч | | |
| 8. | Асрагч | | |
| 9. | Асрагч | | |
| 10. | Асрагч | | |
| 11. | Асрагч | | |
| 12. | Асрагч | | |
| 13. | Асрагч | | |
| 14. | Асрагч | | |
| 15. | Асрагч | | |
| 16. | Асрагч | | |
| 17. | Асрагч | | |
| 18. | Асрагч | | |
| 1 | Статистик бага эмч | | |
| 2 | Халдвар судлагч эмч | | |
| 3 | Эм зүйч эмч | | |
| 4 | Эм найруулагч | | |
| 5 | Нярав | | |
| 6 | Нярав | | |
| 7 | Тогооч | | |
| 8 | Тогооч | | |
| 9 | Тогооч | | |
| 10 | Эмгэг анатомын үйлчлэгч | | |
| 11 | Талбайн цэвэрлэгч | | |
| 12 | Угаалга | | |
| 13 | Ариутгал /автоклавчин/ | | |
| 14 | Ариутгал /дезкамер/ | | |
| 15 | Жолооч | | |
| 16 | Слесарь | | |
| 17 | Слесарь | | |
| 18 | Слесарь | | |
| 19 | Слесарь | | |
| 20 | Манаач | | |
| 21 | Манаач | | |
| 22 | Манаач | | |
| 23 | Манаач | | |
| 24 | Цахилгаанчин | | |
| 25 | Мужаан | | |
| | | | |



НИЙСЛЭЛИЙН ГУРАВДУГААР АМАРЖИХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЖ, ТУС АМАРЖИХ ГАЗРЫН ЗАХИРЛЫН АЖЛЫГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН.

▶ **Ажлын хэсгийн ахлагч:-** Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Ё.Тэрбиш.

● **Гишүүд:-** ЭМНХЯ-ны Салбарын бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Б.Энхжин.

-Мөн яамны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Амар.

-Нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Ж.Энхбаяр.

- Нийслэлийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны дарга Э.Сэржбадам.

- Нийслэлийн өмчийн газрын мэргэжилтэн Г.Цэцмаа.

- Нийслэлийн Тамгын газрын мэргэжилтэн Нямдаш.

- ЭНЭШТөвийн захирал Чойжамц.